

# САНХҮҮГИЙН ЗАЛИЛАН

## ТИПОЛОГИЙН ТАЙЛАН 2022



МОНГОЛБАНК  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН  
АЛБА

## **АГУУЛГА**

1. ТАНИЛЦУУЛГА	2
2. ЗОРИЛГО, БҮТЭЦ	3
3. САНХҮҮГИЙН ЗАЛИЛАН БА МӨНГӨ УГААХ НЬ	4
3.1. Санхүүгийн залилан гэж юу вэ?	4
3.2. Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт	4
4. САНХҮҮГИЙН ЗАЛИЛАНГИЙН ТҮГЭЭМЭЛ ТИПОЛОГИУД	6
5. САНХҮҮГИЙН ЗАЛИЛАНГИЙН ЖИШЭЭНҮҮД	17
6. САНХҮҮГИЙН ЗАЛИЛАНГИЙН ШИНЖ ТЭМДГҮҮД	22
6.1. Санхүүгийн залилангийн үндсэн шинж тэмдэг	22
6.2. Санхүүгийн залилангаар дамжуулан мөнгө угааж байж болзошгүй гэж сэжиглэх ерөнхий үндэслэлүүд	23
6.2.1. Данс нээх үед ажиглагдах шинж тэмдгүүд	23
6.2.2. Гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд	23
6.2.3. Хуурамч компанитай холбогдон илрэх шинж тэмдгүүд	24
7. АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	25
8. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГААР МЭДЭЭЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛ	26
9. ХАВСРАЛТ – КЭЙС ЖИШЭЭ	27

## 1. ТАНИЛЦУУЛГА

Сүүлийн үед ихээр үйлдэгдэж байгаа хэргүүдийн нэг нь санхүүгийн залилан юм. Богино хугацаанд их мөнгөтэй болох гэсэн эсвэл мөнгөө өсгөх үүднээс сайтар нягтлалгүйгээр санхүүгийн харилцаанд орсноос хохирогч болсон иргэд, аж ахуйн нэгжийн тоо сүүлийн үед эрс нэмэгдэж байна (СЗХ, 2021). Тэр тусмаа сүүлийн үед залилан мэхлэгч этгээдүүд иргэдийг итгэн үнэмшүүлэхийн тулд улам бүр боловсронгуй, нарийн арга ашиглах болсон юм. Тухайлбал, хөрөнгө оруулалт мэтээр өнгөлөн гоёсон залилан нь иргэдэд бодит ажил хэрэг мэт төөрөгдөл үүсгэж, мөнгө, хөрөнгө, цаг хугацаагаа алдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Монгол Улсын үндэсний эрсдэлийн үнэлгээгээр “залилах” гэмт хэргийн улмаас олсон орлогоос үүдэлтэй аюул занал “өндөр” хэмжээнд үнэлэгджээ (Үндэсний эрсдэлийн үнэлгээ, 2021). Залилах гэмт хэргийн ангиллаар эрүүгийн хэргийн үндсэн яллагдагчаар татсан хэргийн тоо 2020 оны байдлаар 3,238 буюу нийт хэргийн 34.9 хувийг эзэлж байгаа бөгөөд хулгайлах гэмт хэргийн дараа орж байна. Иймд санхүүгийн залиланг илрүүлэх, мэдээлэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд хувь хүн, банк, санхүүгийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэнэ. Санхүүгийн байгууллагын комплаенсийн нэгж, бизнес/үйл ажиллагааны эрсдэл хариуцсан нэгж болон үйлчилгээний ажилтнууд мэдлэг, мэдээлэл, нэгдсэн ойлголттой байж харилцан уялдаатай, хамтран ажиллах нь зөвхөн санхүүгийн залилан гэлтгүй бусад төрлийн санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, харилцагчийг болон өөрийн байгууллагыг аливаа болзошгүй эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой юм.

Санхүүгийн залилангийн тоо, хохирлын хэмжээ гадаад улсуудад төдийгүй Монгол Улсад эрс нэмэгдэж байгаа бөгөөд энэ залиланд өртөж алдсан хөрөнгө, мөнгийг ихэнх тохиолдолд буцааж олж авч чадахгүй байх магадлал өндрөөс гадна санхүүгийн байгууллагууд болон бизнесийн байгууллага, хувь хүмүүст бодитой аюул занал, хохирол учруулж байгаатай холбогдуулан Санхүүгийн мэдээллийн албанаас санхүүгийн залилангийн тухай, энэ төрлийн залилан луйвар ямар шинж тэмдэгтэй байдаг, ямар арга хэлбэрээр яаж үйлдэгддэг талаар, энэ төрлийн залилангийн шинж тэмдэг илэрвэл ямар арга хэмжээ авах талаар ерөнхий мэдээлэл, ойлголт өгөх зорилгоор мэдээлэх үүрэгтэй этгээд, эрх бүхий бусад байгууллагуудад зориулан энэхүү типологийн тайланг гаргаж байна.

## 2. ЗОРИЛГО, БҮТЭЦ

Санхүүгийн мэдээллийн албанаас энэхүү типологийн тайланг мэдээлэх үүрэгтэй этгээд болон эрх бүхий бусад байгууллагуудын ажилтнуудад санхүүгийн залилантай холбоотой мэдээлэл өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авах мэдлэг, чадавхтай болгох зорилгоор боловсруулан гаргав.

Санхүүгийн залилан үйлдэгддэг арга хэлбэр, типологи болон гарсан бодит жишээ кейсүүдээс харахад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн үр дүнтэй арга зам бол гүйлгээ хийгдэхээс өмнө санхүүгийн залиланг таних, харилцагчид анхааруулж мэдээлэл өгөх, гүйлгээг хийхээс өмнө зогсоох, нэгэнт хийгдсэн гүйлгээний тухайд шилжүүлгийн гүйлгээг маш түргэн шуурхай зогсоох, шилжүүлсэн мөнгийг дагаж хаана, хэнд хүрч байгааг олж мэдэх, холбогдох болон эрх бүхий байгууллагууд аль болох богино хугацаанд дараагийн арга хэмжээг авах явдал юм. Үүнтэй холбогдуулан мэдээлэх үүрэгтэй этгээд болон холбогдох бусад байгууллагууд дараах арга хэмжээг авах шаардлагатай бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг типологийн тайлангийн дараагийн хэсгүүдээр өгөх болно:

- (1) Мэдээлэх үүрэгтэй этгээдийн ажилтнууд санхүүгийн залилангийн талаар ойлголт, мэдээлэлтэй болох, улмаар хууль бус шилжүүлгийн гүйлгээ хийгдэхээс өмнө таньж илрүүлэх, зогсоох арга хэмжээ авах;
- (2) Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг санхүүгийн залиланд өртсөн эсвэл энэ талаар мэдсэн даруйд, мөн харилцагч залиланд өртөн буруу шилжүүлгийн гүйлгээ хийснийг мэдмэгц хууль сахиулах байгууллага, Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх арга хэмжээ авах;
- (3) Хууль сахиулах байгууллага болон Санхүүгийн мэдээллийн алба, гадаад улсын Санхүүгийн мэдээллийн албад хоорондоо хамтран ажиллаж, гэмт хэрэг үйлдэгдсэн даруйд буюу аль болох богино хугацааны дотор (24 цагийн дотор байвал сайн гэж үздэг) луйвардуулсан/залилуулсан мөнгө, хөрөнгийг хаашаа шилжүүлснийг олж тогтоох, царцаах, цаашлаад буцааж олж авах арга хэмжээ авах.

Энэхүү типологийн тайлан нь нийт 9 хэсгээс бүрдэх бөгөөд үүнээс хойших хэсгүүдэд санхүүгийн залилан гэж юу вэ, ямар арга хэлбэрээр үйлдэгддэг вэ, энэ төрлийн залилангийн түгээмэл типологи, жишээ, шинж тэмдгүүд ямар байдаг вэ, Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт, санхүүгийн залиланг илрүүлэх, таслан зогсооход авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн үндсэн асуудлуудын хүрээнд дэлгэрэнгүй мэдээлэл өгөх болно. Мөн илүү ойлгомжтой болгох үүднээс Монгол Улсад болон бусад улс орнуудад гарч байсан бодит кейс жишээ, тохиолдлоос түүвэрлэн танилцуулна.

## 3. САНХҮҮГИЙН ЗАЛИЛАН БА МӨНГӨ УГААХ НЬ

### 3.1. Санхүүгийн залилан гэж юу вэ?

Банк, санхүүгийн байгууллагын цахим сүлжээнд хууль бусаар нэвтрэх, эсвэл хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээлэл ашиглан гайхалтай үр дүн амлах замаар бусдын эд хөрөнгийг завших, эсвэл ямар нэг хууль бус үйлдлээр бусдад санхүүгийн хохирол учруулах үзэгдлийг хэлнэ. Санхүүгийн залиланг хийхдээ хүний хувийн мэдээллийг хулгайлах эсвэл хөрөнгө оруулалт мэтээр луйвардах гэх мэт олон янзын аргаар хийж болно (Victim connect resource center).

Жил бүр тоо томшгүй олон хүмүүс, байгууллага санхүүгийн залилан, луйврын хохирогч болж, хуримтлал, ажлын байр, хөрөнгө оруулалтаа алдаж байгаа бөгөөд үүнээс үүдэн санхүүгийн болон хувийн олон бэрхшээлийг амсаж байна. Санхүүгийн залилан үргэлж санаатай үйлдэгддэг ба залилан үйлдэгчид хүн, байгууллагаас мөнгө, хөрөнгийг нь хууран мэхлэх, төөрөгдүүлэх замаар олж авдаг. Санхүүгийн залилан янз бүрийн арга, хэлбэрээр үйлдэгддэг ба тухайлбал, интернет худалдаа, хуурамч цахим хуудас, вексель, понзи схем, пирамид схем, хөрөнгө оруулалт, криптовалюттай холбоотой залилан, зээлийн картын луйвар, гэрээ болон худалдан авалтын луйвар, хүний хувийн мэдээлэл хулгайлах гэх мэт олон төрлөөр үйлдэгдэж байна.

Санхүүгийн залиланг илрүүлэх, таслан зогсооход хууль сахиулах байгууллага, зохицуулагч байгууллагууд болон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа маш чухал. Хамтын ажиллагааны хүрээнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд санхүүгийн залилангийн эрсдэлд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэхээс гадна, хууль бус ажиллагаа, гэмт хэргийг илрүүлэх, дотоод, гадаадад нуусан, хулгайлагдсан хөрөнгийг буцаан олж авах ч боломжтой юм.

### 3.2. Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт

Залилах гэмт хэрэг нь 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйл болох Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэсэн зүйл ангиар зохицуулагддаг байсан бол 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар тус хуулийн 17.3 дугаар зүйлээр зохицуулагдаж байна.

Эрүүгийн хууль:  
17.3 дугаар зүйл:

- 1. Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол **дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.**
- 2.Энэ гэмт хэргийг:
  - 2.1.албан тушаалын байдлаа ашиглаж;
  - 2.2.бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 3.Энэ гэмт хэргийг:
  - 3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;
  - 3.2.олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн;
  - 3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

## 4. САНХҮҮГИЙН ЗАЛИЛАНГИЙН ТҮГЭЭМЭЛ ТИПОЛОГИУД

### Вексель

Вексель нь төлбөр хариуцагчаас тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр үл маргалдах журмаар вексель эзэмшигчид төлөхийг харилцан тохиролцож баталсан төлбөрийн баримтыг хэлнэ. Вексель нь төлбөр тооцооны үнэт цаас юм. Векселийн хүүг ерөнхийдөө хугацаа дуусахаас өмнө эсвэл хугацаа дуусах үед төлдөг. Компаниуд хөрөнгө босгохын тулд вексель зарж болох бөгөөд ихэвчлэн зөвхөн томоохон хэмжээний эсвэл институцийн хөрөнгө оруулагчдад санал болгодог. Гэхдээ хувь хөрөнгө оруулагчдад вексель санал болгож, зарах тохиолдол бий. Олон нийтэд худалдсан ихэнх вексель нь үнэт цаасны зохих лицензтэй эсвэл улсын үнэт цаасны агентлагийн бүртгэлтэй үнэт цаасны сан эсвэл брокер, дилерээр зарагдах ёстой байдаг. Хууль ёсны үнэт цаас гаргагчдаас гаргасан вексель нь эрсдэлийн зөвшөөрөгдөх түвшинд хөрөнгө оруулалтын боломжийн өгөөжийг өгч чадна.

Энэхүү векселиэр үйлдэгдэх залилан нь голлон ахмад настан болон тогтмол орлогоор амьдардаг хүмүүсийг уруу татахыг эрмэлзэж байлаг. Иймд вексельд хөрөнгө оруулахаар төлөвлөж буй хүмүүс хөрөнгө оруулалт болон түүнийг сурталчилж буй хүмүүсийг сайтар судлах хэрэгтэй юм (Washington State Department of Financial Institutions).

Хэрхэн үйлдэгддэг вэ?

Бүхий л төрлийн хөрөнгө оруулалт нь тодорхой хэмжээний эрсдэлтэй байдаг хэдий ч залиланг үйлдэгч нь тус векселийг танаас богино хугацаанд зээлж буй өндөр хүүтэй, ямар ч эрсдэлгүй, баталгаажсан бүтээгдэхүүн хэмээн ойлгуулж зарахыг оролдоно. Ямар ч хөрөнгө оруулалт нь тодорхой хэмжээний эрсдэлийг агуулж байдаг. Тухайн векселийг гаргаж буй компани нь гарааны бизнес юм уу эсвэл огт байдаггүй компани байвал өндөр зэрэглэлийн хөрөнгө оруулалт мэт харагдуулахын тулд вексель дээрээ “дээд зэргийн, өндөр түвшний” гэх мэт үгсийг байршуулсан байдаг.

Бусад санхүүгийн залилангийн нэгэн адил залилагч таны итгэлийг олж авахын тулд анхны төлбөрийг таны данс руу оруулж болно. Гэсэн хэдий ч цаг хугацаа өнгөрөх тусам төлбөр нь тасалдах эсвэл хэмжээ нь буурч эхэлдэг байна (InvestRight).

Дараах гол шинж чанартай байна. Үүнд:

- Ямар ч гарааны бизнес болон компани нь хөрөнгө оруулагчдадаа “дээд зэргийн, өндөр түвшний” гэх векселийг худалдаалдаггүй;
- Ижил төрлийн хөрөнгө оруулалтын өгөөжөөс өндөр байх;
- Богино хугацааны, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хэмээн сурталчлах;
- Хөрөнгийн биржид бүртгэлгүй байх.

## Понзи схем

Өнгөрсөн зууны хориод онд амьдарч байсан Чарльз Понзи гэгч Итали гаралтай цагаач эр понзи схемийн залиланг 1919-1920 онд гаргаж ирсэн бөгөөд эхний хөрөнгө оруулагчдад амласан өгөөжийг шинэ хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр төлдөг санхүүгийн луйврын нэг төрөл юм.

Хуучин хөрөнгө оруулагчдын ашгийг шинэ хөрөнгө оруулагчдаас татсан мөнгөөр төлөх замаар энэ схем ажилладаг тул сүүлд хөрөнгө оруулсан хүмүүс хохирч үлддэг. Хөрөнгө оруулагчдыг татахын тулд понзи схемийн залилагчид маш бага эсвэл ямар ч эрсдэлгүй өндөр ашиг хүртэх хөрөнгө оруулалтыг амладаг.

Понзи схемчид өөр хууль ёсны орлогогүй тул томрохын хэрээр өмнөх хөрөнгө оруулагчдад амласан өгөөжийг өгч, оршин тогтнохын тулд байнгын шинэ мөнгөний урсгал буюу хангалттай олон шинэ хөрөнгө оруулагч олох шаардлагатай болдог. Тиймээс шинээр хөрөнгө оруулагч элсүүлж чадахгүй, эсвэл өмнөх хөрөнгө оруулагчид олноороо оруулсан хөрөнгөө авч эхлэхэд энэхүү луйврын схем тогтворгүй болж нурдаг бөгөөд залилагч нь байгаа мөнгөө аваад зугтах эсвэл зохицуулалтын байгууллага болон хууль сахиулах байгууллагад баригдсанаар дуусдаг байна (СЗХ, 2021; InvestRight).

## Пирамид схем

Санхүүгийн пирамид бол шинээр гишүүн элсүүлэх замаар үйлдэгддэг санхүүгийн луйврын төрөл юм. Пирамид схемийн сурталчлагч богино хугацаанд өндөр өгөөж авах боломжийг амлан шинээр элсэгчдийн төлсөн гишүүнчлэлийн мөнгийг өмнө элссэн гишүүдэд өгөх замаар үйл ажиллагаа явуулж, бүтээгдэхүүн үйлчилгээ бодитоор зардаггүй.

Залилагчид пирамидын схемийг олон нийтийн сүлжээ, интернет, компанийн веб сайт, танилцуулга, Youtube видео болон бусад хэрэгслээр байнга сурталчилж байдаг. Хууль ёсны олон түвшний маркетингийн компаниуд гишүүн элсүүлж бус бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтаас орлого олдог бол пирамид схемийн сурталчлагчид өөрийн луйврын үйлдлийг халхавчлахын тулд бүтээгдэхүүн үйлчилгээ зарах зорилготой хууль ёсны олон түвшний маркетингийн бизнес мэт харагдуулахын тулд ихээхэн хүчин чармайлт гаргадаг.

Пирамид схем хэт том болсноор өмнөх гишүүдэд өгөх өгөөжийг төвлөрүүлэх хэмжээний хөрөнгө оруулалт татах гишүүн шинээр элсүүлж чадахгүйд хүрч, пирамид нурж хүмүүс мөнгөө алдаж эхэлдэг (СЗХ, 2021; InvestRight).

## Үл хөдлөхийн хөрөнгө оруулалт

Үл хөдлөх хөрөнгийн схемүүд нь худалдан авагчдад богино хугацааны зээл, компаниудад барилгын зээл, тэр байтугай барилгын хувьцаа хэлбэрээр зарагдаж, орлого олон хөрөнгө оруулагчдад төлдөг. Үл хөдлөх хөрөнгө гэх мэт биет хөрөнгөөс тогтвортой орлого хайж байгаа хөрөнгө оруулагчдад өндөр, баталгаатай өгөөжийг санал болгоно.



Олон хүмүүс үл хөдлөх хөрөнгөө хувийн хөрөнгө оруулалт эсвэл амьдрах байр болгон худалдаж авдаг бол заримдаа үл хөдлөх хөрөнгө нь үнэт цаас хэлбэрээр зарагддаг. Энэхүү нөхцөлөөр худалдан авагч нь үл хөдлөх хөрөнгө худалдан авах бөгөөд өгөөж авах боломж бүрддэг.

Хууль бус схемийг ихэвчлэн эрчимтэй сурталчилгаагаар (мэдээний нийтлэл болгон хувиргасан зар сурталчилгаа) сурталчилж, хэдхэн жилийн дотор хөрөнгө оруулагчдад их хэмжээний ашиг өгөх амлалтыг өгдөг. Хөрөнгө оруулагчид үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, эзэмшихэд ашигладаг хөрөнгийн санд хувь оруулна.

Хууль бус схемд хөрөнгө оруулагчдыг татахын тулд үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг заримдаа хөөрөгддөг ба зарим тохиолдолд эд хөрөнгө огт байдаггүй. Бусад олон санхүүгийн залилангийн схемийн нэгэн адил хөрөнгө оруулалт хийсний дараа харилцаа холбоо суларч эсвэл тасардаг (InvestRight).

Эдгээр нийтлэг шинж тэмдгүүдийн аль нэгийг анхаарч үзэх хэрэгтэй:

- Хурдан баяжихыг санал болгох эсвэл үл хөдлөх хөрөнгийн нэмэлт орлогоор мөрөөдлийнхөө тэтгэвэрт гарахыг амлах;
- Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт, зээлтэй холбоотой баримт бичиг, мэдээлэл дутмаг байх;
- Тухайн компани эсвэл хөрөнгө оруулалт нь үнэт цаасны зохицуулах байгууллагаар зөвшөөрөгдсөн танилцуулгагүй байх;
- Үнэт цаасны зохицуулах байгууллагад бүртгүүлээгүй байх.

### Криптовалюттай холбоотой хөрөнгө оруулалт

Криптовалют нь криптографиар хамгаалагдсан блокчейн сүлжээнд арилжаалагдах, хадгалагдах үнэ цэнэ бүхий виртуал хөрөнгийн нэг төрөл юм. Криптовалюттай холбоотой хөрөнгө оруулалтын залилан дараах маягаар явагдана (InvestRight; Washington State Department of Financial Institutions). Үүнд:

- Гэмт хэрэгтэн хөрөнгө оруулагчийн мөнгийг крипто хөрөнгийн арилжааны платформд байршуулахаас гадна өндөр баталгаатай өгөөжтэй, маш бага эсвэл огт эрсдэлгүй хэмээн амалдаг байна.
- Цахим мөнгө ашиглан хөрөнгө оруулагч хөрөнгөө оруулах үед гэмт хэрэгтэн харилцаа холбоогоо таслах ба хөрөнгө оруулагчийн мөнгийг хил дамнуулан шилжүүлж, буцааж авахад маш хэцүү болгодог.
- Хөрөнгө оруулагч криптовалютын арилжааны платформ руугаа нэвтэрч өөрийн дансаа шалгах үед маш их хэмжээний өгөөж хүртсэн мэт харагдах боловч арилжааны ашиг нь хуурамч байх магадлалтай.
- Крипто хөрөнгийн арилжааны платформоос бодитоор оршдоггүй ашгийг татах үед гэмт хэрэгтэн хөрөнгө оруулагчаас татвар болон бусад шимтгэл төлбөртэй холбогдуулан дахин мөнгө явуулахыг шаардана. Мөнгийг хүлээж авсны дараа хөрөнгө оруулагчийн мөнгийг хил дамнуулан шилжүүлж дахин дахин хохиролд оруулсаар байх юм.

Криптовалюттай холбоотой хөрөнгө оруулалтаар дамжин хийгдэх санхүүгийн залилан нь дараах үндсэн шинж чанартай байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын баталгаатай өндөр өгөөж;
- Ойлгоход хэцүү үг хэллэг ашиглаж ярих;
- Зөвшөөрөлгүй борлуулагч;
- Асуугаагүй байхад янз бүрийн санал тавих;
- Худалдан авахуулах гэсэн дарамт. “Оройтохоос өмнө” гэх мэтээр хөрөнгө оруулахыг яаруулах.

### Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл/интернет хөрөнгө оруулалт

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь маш хялбараар хүмүүстэй харилцах болон дэлхий даяар контентээ түгээх асар их боломжийг олгож байна. Гэмт хэрэгтнүүд хуурамч хөрөнгө оруулалтын боломжийг сурталчлах зорилгоор энэхүү давуу талыг ашигладаг байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь тэдэнд боломжит хөрөнгө оруулагчдыг чиглүүлэх боломжийг олгодог бөгөөд тэр ч байтугай нийтлэг ашиг сонирхлын хуурмаг байдлыг бий болгодог.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан гэмт хэрэгтнүүд олон янзын хүмүүстэй харьцангуй хямд зардлаар холбогдох боломжтой байдаг. Тэд хуурамч бүртгэл, цахим хаяг үүсгэн, хөрөнгө оруулалтыг хууль ёсны мэт харагдуулах вэбсайт, видео, зурагтай нийтлэлээ холбодог.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэрээ нууцлах боломжтой байдаг нь залилан мэхлэгчдийг илрүүлэх, олоход хэцүү болгодог.

Хэрэв тус залилан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдах юм бол хөрөнгө оруулалтыг хууль ёсны гэж үзэж буй хүмүүс сүлжээн дэх бусад хүмүүсийг хөрөнгө оруулалт хийхийг уриалах болно. Улмаар тэдгээр хүмүүсийн найз нөхөд, гэр бүлийн гишүүд, хамтран ажиллагсад нь хөрөнгө оруулалт хийн санхүүгийн залиланг дэмжихэд хүргэдэг байна. Хэрэв хөрөнгө оруулалт бүтэлгүйтэж эсвэл залилангийн шинжтэй гэдэг нь ил болвол мөнгөө алдах, цаашилбал тэдгээрийн хувийн харилцаанд сөргөөр нөлөөлдөг ажээ.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл/интернет хөрөнгө оруулалтын санхүүгийн залилан нь дараах үндсэн шинж чанартай байна (Washington State Department of Financial Institutions; InvestRight). Үүнд:

- Таны хүсээгүй эсвэл сонирхоогүй хөрөнгө оруулалт хийх санал тавих;
- Ямар нэгэн үндэслэлгүй зөвлөмжийг санал болгох;
- Эрсдэлгүй бөгөөд өндөр өгөөжтэй хэмээх. Өдрийн 2 хувь, 7 хоногийн 14 хувь эсвэл сарын 40 хувь хэмээж байгаа бол анхааралдаа авах хэрэгтэй.
- Цахим валютын сайтууд. Мөнгө шилжүүлэхийн тулд цахим валютын данс нээлгэх шаардлагатай бол болгоомжтой байх хэрэгтэй. Эдгээр сайтууд ямар ч зохицуулалтгүй байж магадгүй бөгөөд хууран мэхлэгчид мөнгөтэй холбоотой ул мөрийг далдлах зорилгоор ашигладаг.

- Найзуудаа элсүүлэхийг уриалах. Ихэнх залилангийн арга хэрэгсэл таныг найзуудаа элсүүлвэл бонустай хэмээх арга техникийг ашигладаг.
- Мэдээлэл багатай эсвэл огт мэдээлэлгүй мэргэжлийн вэбсайтууд. Луйврын сайтууд нь мэргэжлийн мэт харагдах боловч компанийн удирдлага, байршил, хөрөнгө оруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл нь байдаггүй.
- Онлайн залиланг сурталчлагчид хөрөнгө оруулалтын эрсдэл, мөнгөө хэрхэн авах журмын талаар дэлгэрэнгүй танилцуулга эсвэл бусад хэлбэрээр бичгэн мэдээлэл өгөхгүй байх нь элбэг.

### Ковид-19 цар тахалтай холбоотой залилан

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэх бүтээгдэхүүн, үйлчилгээтэй гэж мэдэгдэн гэмт хэрэгтнүүд залилан үйлдэх болсон байна (InvestRight).

### Алтны хөрөнгө оруулалт

Алт зэрэг үнэт металлын давуу тал нь гарт баригдах чанар, найдвартай байдал, мөн зах зээлийн уналтын үед үнэ нь байнга өсдөг явдал юм. Энэ нь эдийн засгийн тодорхой бус үед ялангуяа хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах нэгэн үндэслэл болдог. Залилагчид үүн дээр тоглон гэнэн итгэмтгий хүмүүсийг сэжигтэй санхүүгийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулахын тулд янз бүрийн тактик ашигладаг (InvestRight).

### Хоёртын хувилбарын залилан /Binary options scam/

Хоёртын хувилбарын залилан нь хөрөнгө оруулагчид тодорхой нэгэн хөрөнгийн гүйцэтгэл дээр буюу ихэвчлэн валют, хувьцааны индекс эсвэл хувьцааны гүйцэтгэлд богино хугацаанд заримдаа минут, секундын дотор тавих нэгэн төрлийн бооцоог хэлнэ. Энэ хугацаа дуусахад хөрөнгө оруулагч зөв таасан бол оруулсан хөрөнгөнийхөө өгөөжийг авах эсвэл таагаагүй бол бүх бооцоогоо алддаг.

Хоёртын хувилбарын залилан нь тодорхой нэг төрлийн хөрөнгө оруулагчдад чиглэдэггүй. Ихэнх тохиолдолд хүмүүс хөрөнгө оруулалт хийж, бооцоо тавьж байгаа зүйлээ хууран мэхлэх шинж чанартай эсэхийг бодохгүйгээр мөнгө олох гайхалтай арга замд хүрсэн мэтээр санадаг. Эдгээр луйврын ихэнх нь хууль ёсны хөрөнгө оруулалтыг санал болгож байгаа мэт харагдуулдаг хуурамч хоёрлосон сонголтын вэбсайтууд дээр явагдах бөгөөд залилагчид програм хангамжид хууль бусаар нөлөөлж, үнэ, сонголтыг өөрсдийн дураар өөрчилдөг байна. Цаашлаад тэд хөрөнгө оруулагчийн мөнгийг өгөлгүй, тэдний арилжаа, бооцооны дансыг гэнэт хаадаг байна. Эдгээр вэбсайт дээр байх хөрөнгө оруулагчдын харж буй арилжааны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын өгөөж нь бодитой биш юм (InvestRight).

Хоёртын хувилбарын залилан нь хэрхэн явагдах вэ?

Хоёртын хувилбарын залиланг ихэвчлэн вэбсайт болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилдаг. Ихэнхдээ зар сурталчилгаа нь эдгээр бүтээгдэхүүнийг худалдаалах нь хэр хялбар бөгөөд ашигтай болох тухай харуулах эсвэл хөрөнгө оруулалтын салбарт хоёрлосон сонголтын хөрөнгө оруулалт нь хэрхэн шинэ зүйл

болохыг харуулна. Залилагчид Google, Bing зэрэг хайлтын системээр дамжуулан онлайнаар хөрөнгө оруулалт хайж буй хүмүүсийг олж онилдог байна. Тэд хүмүүсийг хөрөнгө оруулалт хийлгэж, бооцоо тавиулуулахын тулд өндөр өгөөж санал болгож болох ч зарим нь илүү хууль ёсны мэт харагдахын тулд илүү бодитой саналыг санал болгож магадгүй юм.

Хөрөнгө оруулагчид ихэвчлэн данс үүсгэж, мөнгөө байршуулан хэдхэн цагийн дотор хоёр хувилбарын аль нэгэнд бооцоо тавьж эхэлдэг байна. Хөрөнгө оруулагчид буюу бооцоо тавьсан этгээд залилуулсан гэдгээ оруулсан мөнгөө авах боломжгүй байх үед эсвэл бооцоогоо авах боломжгүй гэдгийг мэдэх үед л ойлгодог. Залилагчид эцэст нь вэбсайтыг хааж, хөрөнгө оруулагчдын бүх мөнгийг авдаг. Зарим тохиолдолд зээлийн карт болон банкны мэдээлэл хулгайд алдагддаг бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдад илүү их хохирлыг учруулдаг.

Тус төрлийн залилан нь эдгээр шинж чанартай байна. Үүнд:

- Хоёртын хувилбарын арилжаа / бооцоогоор хурдан мөнгө олох боломжтой гэсэн вэбсайтууд эсвэл гар утасны програмууд;
- Оффшор опционы арилжаанд оролцох зар сурталчилгаа;
- Эрсдэл багатай бөгөөд богино хугацаанд өндөр өгөөж өгдөг гэх;
- Хөрөнгө оруулалтыг оффшор, татваргүй гэж маркетинг хийх;
- Шинэ данс нээгээд үнэгүй мөнгө авахыг санал болгох;
- Яг одоо бүртгүүлж, онцгой боломжийг ашиглахыг ятгах.

## Форекс

Форекс буюу гадаад валютын зах зээл нь үндсэндээ нэг валютыг худалдан авч байхад нөгөөг нь зарах явдал юм. Ашиг, алдагдал нь валют хоорондын ханшийн хэлбэлзлээс хамаардаг.

Форекс залилан нь хөрөнгө оруулагчдад гадаад валют руу хөрөнгө оруулах боломжийг санал болгодог боловч залилангийн шинжтэй байдаг. Форекс арилжаа нь маш өндөр эрсдэлтэй. Мэргэжлийн брокеруудыг ажиллуулдаг, сая сая долларын арилжааны данс ажиллуулдаг, нарийн технологи ашигладаг томоохон санхүүгийн байгууллагууд ч гэсэн энэ зах зээл дээр мөнгө олох нь хэцүү байдаг.

Тус зах зээлийг сурталчилахдаа хүмүүс ихэвчлэн телевиз, интернет, радиогоор зар сурталчилгаа явуулах замаар хөрөнгө оруулагчдыг олдог. Зарим нь хөрөнгө оруулагчдыг хайж олохын тулд ойр дотны бүлэг, найз нөхөд, гэр бүлийнхнээ ашигладаг бөгөөд санхүүгийн байгууллагат ажилладаг мэргэжлийн шинжээчид, арилжаачидтай хөрөнгө оруулалт хийх боломжийг амладаг.

Тус зах зээлийг сурталчлагчид ихэвчлэн өндөр өгөөж амладаг. Тэд хүмүүс, байгууллагыг арилжааны семинарт оролцох эсвэл форекс зах зээлийн нууцыг тайлах програм хангамж худалдаж авахыг ятгах болно. Уг сурталчилгаанд хүмүүс, байгууллагыг эерэг үйл хөдлөл үзүүлэхэд форекс зах зээлд оролцож байгааг нь урамшуулж магадгүй байдаг. Тэд гэрээ байгуулан оролцогчдын мөнгийг оффшор данс руу хийхийг оролдох бөгөөд оролцогчид

хөрөнгө оруулаад хэсэг хугацаа өнгөрсний дараа тус хөрөнгө оруулалт нь залилан эсвэл понзи схемийн нэг хэлбэр байсныг мэдэх болно (InvestRight).

Дараах шинж чанараар энэхүү залиланг таньж мэдэх боломжтой. Тухайлбал:

- Мэргэшсэн валютын арилжаачдын удирддаг санд мөнгөө байршуулах санал тавих;
- Эрсдэл багатай эсвэл огт байхгүй гэх ба хөрөнгө оруулалтын өндөр өгөөжийн баталгааг амлах;
- Арилжаачдын өнгөрсөн хугацаанд хийж байсан арилжааны амжилт болон гүйцэтгэлийн талаар хэлэлцэх хүсэлгүй байх;
- Хөрөнгө оруулалт худалдаж авах, програм хангамж худалдаж авах, сургалтанд хамрагдахыг тулгаж шахах.

### Оффшор хөрөнгө оруулалтын схем

Оффшор хөрөнгө оруулалтын схем нь олон хэлбэрээр явагддаг боловч нэг нийтлэг шинж чанартай байдаг бөгөөд хөрөнгө оруулагчийг өөр улс руу мөнгөө шилжүүлэхийг хүсдэг байна. Тэднийг мөнгөө оффшор руу шилжүүлсний дараа залилагчид хоёр ба түүнээс дээш удаа мөнгөн шилжүүлэг хийдэг. Ингэснээр залилсан мөнгийг хаана байгааг далдалдаг бөгөөд хилээр дамнан мөнгө шилжүүлэх нь залилагч баригдахгүй байх нөхцлийг бүрдүүлж өгдөг байна (InvestRight).

Энэ төрлийн хөрөнгө оруулалтыг сурталчлагчид семинар, сурталчилгаа, ам дамжсан яриагаар дамжуулан хөрөнгө оруулагчдыг татдаг. Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр олны анхаарлыг ихээр татаж байна.

Хөрөнгө оруулагчийн мөнгөө илгээж байгаа компани нь хуурамч эсвэл хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн мөнгийг шилжүүлэх зорилгоор байгуулагдсан компани байж болзошгүй. Оффшор компани руу мөнгөө илгээсний дараа тус мөнгийг шилжүүлэн жишээлбэл, Панам дахь холдинг компанид хадгалуулдаг.

Энэхүү схемийн нэг гол шинж чанар нь тус хөрөнгө оруулалт нь татвараас зайлсхийх эсвэл бууруулах боломжтой хэмээн сурталчилна.

Тус төрлийн залилан нь эдгээр шинж чанартай байна. Үүнд:

- Өөр улс руу мөнгө шилжүүлэхийг хүсэх;
- Үнэт цаасны зохицуулах байгууллагад бүртгүүлээгүй байх;
- Өндөр өгөөж, татварын хэмнэлтийг санал болгох;
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, хөрөнгө оруулалт, менежментийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулаагүй баримт бичигтэй байх.

### Бойлерийн өрөө буюу дарамт шахалт үзүүлэх тактик бүхий схем /Boiler room scam/

Бойлерийн өрөө схем нь боломжит хөрөнгө оруулагчид руу залгаж, тэднийг хөрөнгө оруулалтыг хийхийг шаарддаг санхүүгийн залилан юм. Энэхүү луйврын хэлбэр нь хохирогчид дарамт шахалт үзүүлэн тулгах байдлаар хийгддэг тул бойлерийн өрөөтэй

зүйрлэн ингэж нэрэлсэн байна. Тус төрлийн залиланг үйлдэгчид үнэт цаасны зохицуулагч болон хууль сахиулах байгууллагуудын хяналт шалгалтаас зайлсхийхийн тулд ихэвчлэн зорилтот хүмүүсээсээ өөр харьяалалтай байх, өөр улс оронд байгуулагдсан байдаг (InvestRight).

Тус төрлийн залилан нь утасны дуудлагаар эхлэх ба таныг утсаа авсны дараа сурталчилж буй компанидаа хөрөнгө оруулахыг тулгаж ятгана. Ихэнх тохиолдолд тухайн компани нь хувийн байх бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр их гардаг бизнес жишээлбэл алтны олборлолтыг эрхэлдэг гэж хэлнэ.

Хөрөнгө оруулагч руу залган хэлсэн сурталчилгааны ажилтнууд эсвэл тэдний төлөөлөгч хөрөнгө оруулагчид мөнгөө аливаа нэгэн банкны данс руу шилжүүлэхийг зөвлөж, хувьцааны гэрчилгээ илгээнэ гэж амлана. Хөрөнгө оруулалт хийгээд хэсэг хугацаа өнгөрсний дараа тэрхүү компани байдаггүй гэдгийг олж мэдэх болно.

Дараах шинж чанараар энэхүү залиланг таньж мэдэх боломжтой. Тухайлбал:

- Хөрөнгө оруулалтыг нэн даруй хийлгэхийн тулд борлуулалтын түрэмгий арга техникийг ашиглах, тухайлбал, хөрөнгө оруулагчийг шууд хариу өгөхийг шаардах эсвэл саналыг өөр хүнд тавина гэх;
- Хөрөнгө оруулагчаас мэдээллийг нууцлахыг хүсэх;
- Санал тавьж буй компани ихэвчлэн гадаад улсын компани байх боловч дотоодод бүртгэлтэй утасны дугаараас залгах;
- Хөрөнгө оруулалтын талаар бодит мэдээлэлгүй, тодорхой бус, сурталчилгааны хэллэг агуулсан вэбсайт эсвэл бичиг баримттай байх;
- Бодит бус өгөөжийг амлах;
- Хувьцаа, бонд гэх мэт хөрөнгө оруулалт хийх талаар дахин дахин утсаар холбогдох – зарим тохиолдолд 20-30 удаа залгасан тохиолдол гарсан байдаг.

### Сэргээх өрөөний схем /Recovery room scam/

Өмнө нь залиланд өртсөн хүмүүсийг дахин залилдаг тул уг залиланг сэргээх өрөөний схем хэмээн нэрлэдэг байна. Энэ залилангийн үед анхны залиланг хийсэн этгээдүүд өмнөх залилан /boiler room scam гэх мэт/-д өртөж мэхлэгдсэн эсвэл мөнгөө алдсан хөрөнгө оруулагчтай дахин холбогдон, өөр компанийн дүр эсгэж, хохирсон хөрөнгө оруулагчид мөнгөө буцааж авахад нь төлбөртэй туслахыг санал болгодог. Гэхдээ мөнгийг нь хэрхэн олж өгөх талаар ямар ч тайлбар мэдээлэл өгдөггүй эсвэл худал мэдээлэл өгдөг. Ингэхдээ тэд дүр эсгэж, хөрөнгө оруулагчийн алдсан мөнгийг олж авч өгөхийн тулд Засгийн газар, цагдаа эсвэл бусад зохицуулагчтай хамтран ажиллана гэж хэлж ч болно. Ерөнхийдөө энэ төрлийн залилангийн үед хөрөнгө оруулагчийн хохирлыг барагдуулах аливаа үйлчилгээ үзүүлэхээс өмнө хураамж эсвэл гүйлгээний төлбөр төлөхийг шаарддаг. Тухайн мэдээлэлд итгэн мөнгөө шилжүүлснээр хохирогч дахин мөнгөө алддаг байна.

### Өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Энэхүү хөтөлбөр нь өдөр бүр, долоо хоног бүр эсвэл сар бүр маш өндөр өгөөжийг санал болгох вэбсайтуудыг ашигладаг. Тухайн вэбсайт нь компанийн байршил, удирдлагын

талаар, хөрөнгө оруулагчаас хүлээн авсан хөрөнгөө хэрхэн удирддаг талаар маш бага мэдээлэлтэй байдаг. Гэсэн хэдий ч тус хөтөлбөр нь найдвартай онлайн данс, хөрөнгө оруулалтын онцгой бүтээгдэхүүн эсвэл хадгаламжийн дансаараа сайрхдаг байна (InvestRight).

Тус төрлийн залилан нь эдгээр шинж чанартай байна. Үүнд:

- Хувьцаа, бонд, хадгаламжийн дансыг санал болгодог вэбсайтууд нь өндөр өгөөж (жишээлбэл, өдөрт 2%, долоо хоногт 14% эсвэл сард 48%) амлах;
- Өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн эсвэл өндөр өгөөжтэй хадгаламжийн дансуудыг санал болгодог вэб сайт руу холбосон онлайн зар сурталчилгаа;
- Өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн талаар бодитыг хуурамчаас нь салгаж үнэлдэг вэбсайтууд.

### Романтик буюу хайр дурлалын залилан

Романтик буюу хайр дурлалын залилангийн үед залилагч этгээд хохирогчийн хайр, итгэлийг олж авахын тулд онлайнгаар хэн нэг хүний дүрийг хуурамчаар эсгэн харилцаж эхэлдэг. Дараа нь залилагч этгээд хохирогчийг хууран мэхлэх, санхүүгийн залилан үйлдэхийн тулд романтик эсвэл ойр дотны харилцааны хуурмаг байдлыг тодорхой хугацааны турш бий болгож, эцэст нь хохирогчоос мөнгийг нь ямар нэг арга, шалтгаан ашиглаж өөр лүүгээ шилжүүлүүлж залилдаг байна.

Залилагчид зорилтот хүмүүсээ олохын тулд дараах нийтлэг алхмыг хийдэг байна. Үүнд:

1. Профайл хаяг үүсгэх: Албан ёсны болзооны аппликейшн, олон нийтийн сүлжээ /фейсбүүк гэх мэт/ болон вебсайтад профайл нээх ба ямар нэгэн хувьцааны зураг эсвэл хэн нэгний мэдээлэл, зургийг ашиглан хуурамч профайлыг үүсгэнэ.
2. Анхаарал татах: Болзооны аппликейшн эсвэл олон нийтийн сүлжээгээр дамжуулан хүмүүстэй яриа өдөн, түүний хуурамч профайл буюу заль мэхэнд хууртах хэн нэгнийг хүлээдэг. Тухайн зорилт нь биелмэгц яг л жинхэнээр тухайн хүнийг сонирхож байгаа мэт яриа өдөж харилцан яриа үүсгэж эхэлдэг.
3. Итгэл үүсгэх: Зорилтот хүний итгэлийг үүсгэх зорилгоор байнгын эелдэг үгтэй хайрын мессежийг явуулна.
4. Санхүүгийн тусламж хүсэх: Итгэлийг нь олж авсны дараа залилагч этгээд санхүүгийн асуудал, хүндрэлд орсон тухай дурдах бөгөөд ямар ч төрлийн нөхцөл байдалд орсон хэмээн хэлж болно. Тухайлбал, бизнесийн хүндрэл үүссэн, хөрөнгө оруулалтын боломж гарч ирлээ, гэр бүлийн тулгамдсан асуудалтай болсон эсвэл уулзахад мөнгөний асуудалтай байгаа учраас онгоцны билетний төлбөр төлөхийг гуйх, бэлэг явуулсан боловч гаалийн татвар төлөх хэрэгтэй байна гэх мэт янз бүрийн олон шалтгаг шалтгаан, нөхцөл байдлыг хэлж болно.

Дараах нөхцөл байдлаар дамжуулан тус залиланг таньж мэдэх боломжтой. Үүнд:

- Биечлэн уулзаж чадахгүй байх;

- Видео дуудлага хийхээс татгалзах;
- Харилцааныхаа эхэн үед л өөрт тань маш хайртай болсноо хэлж, хайрын мессеж зогсоо зайгүй илгээх;
- Тэд яриагаа санхүүгийн асуудал руу чиглүүлж мөнгө гуйх.

### Олонд танигдсан томоохон банкны схем

Энэхүү схемийн нийтлэг тал нь ихэвчлэн оффшор бүсэд байдаг дэлхийн шилдэг, олонд танигдсан банкуудын баталгаатай өрийн бичгийг (жишээлбэл, зээл, бонд эсвэл өрийн бичиг) худалдан авах явдал юм. Тус схемийг тайлбарлахдаа сурталчлагчдын ашигладаг нийтлэг нэг арга нь банкаар баталгаажсан арилжааны хөтөлбөр, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын хөтөлбөр, банкнаас гаргасан өрийн бичиг гэх мэтээр сурталчилна. Тэд энэхүү хөрөнгө оруулалтыг дэлхийн томоохон банкууд зөвхөн баян, хүчирхэг хувь хүмүүс эсвэл корпорациудын хөрөнгө оруулдаг хөрөнгө оруулалтын боломж хэмээдэг (InvestRight).

Хөрөнгө оруулагчдаас оролцогч талуудын нэр, гүйлгээний нөхцлийг задруулахаас сэргийлж гэрээнд гарын үсэг зурахыг шаардаж болно. Ингэх нь хөрөнгө оруулалтын нөхцөл, нууцлалыг хадгалахад зайлшгүй шаардлагатай зүйл хэмээн хэлдэг. Гэсэн хэдий ч, энэ нь залилагчдын заль мэх илрэхээс өмнө оффшор данс руу мөнгө шилжүүлэх цагийг уртасгаж буй хөрөнгө оруулалтын схемд ашигладаг түгээмэл нэгэн арга юм.

Тус схемд амласан жилийн өгөөж нь ихэвчлэн 20 хувиас 200 хувь хүртэл байдаг. Хөрөнгө оруулагчдын авдаг өгөөж нь бусад хөрөнгө оруулагчдын оруулсан мөнгөнөөс орж ирдэг. Уг схемийг зохион байгуулж буй хүмүүс бүх мөнгийг оффшор данс руу хийх эсвэл зарцуулснаас болж эцэстээ зогсдог байна.

Тус төрлийн залилан нь эдгээр шинж чанартай байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтыг олон улсын эсвэл төв банкнаас баталгаажуулсан баталгаатай гэх;
- Энэ хөрөнгө оруулалтын нууцлал, онцлог байдлыг хадгалахын тулд гэрээнд гарын үсэг зурахыг шаардах;
- Хөрөнгө оруулалт хэрхэн явагддагийг тайлбарлахад тодорхой бус, нарийн төвөгтэй нэр томъёог ашигладаг бөгөөд зохион байгуулж буй хүмүүс нь үүнийг ихэнх хүмүүс ойлгоход хэтэрхий төвөгтэй гэж хэлэх;
- Цаг хугацаа өнгөрөх тусам өндөр өгөөжийг амлах.

### Хуурамч СВИФТ-ийн баримт ашиглан хийх залилан

СВИФТ нь олон улсын санхүүгийн мэдээлэл дамжуулах хамтын нийгэмлэг бөгөөд дэлхий даяар СВИФТ-ийн мессеж сүлжээг өдөр бүр 200 гаруй улс оронд 42 сая орчим төлбөрийн гүйлгээг дамжуулахад ашигладаг. Гишүүн байгууллагууд зорилгоосоо хамааран хэд хэдэн форматаар (Mt100-Mt999) мессеж үүсгэдэг.

СВИФТ-ийн мессежний баримтыг хуурамчаар үйлдэн хөрөнгө оруулалтын залилан хийх хэрэг Монгол Улсын хувьд сүүлийн үед түгээмэл гарч байна. Тухайлбал, аливаа нэгэн хуулийн этгээдэд төсөл, хөтөлбөрт нь санхүүжилт хэрэгтэй байгаа үед урьд өмнө



харилцаж байгаагүй, олон нийтэд танигдаагүй гадаадын байгууллагаас тухайн төслийг санхүүжүүлэх саналыг тавих үед тус залилан явагдах нөхцөл бүрддэг ажээ.

Залилагчид зорилтот хүмүүсээ олохын тулд дараах нийтлэг алхмыг хийдэг байна. Үүнд:

1. Төсөл хөтөлбөрт нь санхүүжилт хэрэгтэй байгаа этгээдийг онилох.
2. Санхүүжилт хэрэгтэй этгээдийн төсөлд хөрөнгө оруулахаар тохиролцох: Залилан мэхлэгч этгээдүүд санхүүжилт хэрэгтэй байгаа хуулийн этгээдтэй тухайн төсөлд нь хангалттай хэмжээний буюу маш өндөр дүнтэй (ихэвчлэн 1 сая евро болон доллараас дээш) хөрөнгө оруулалтыг хийхээр тохиролцдог байна.
3. Санхүүжилт хэрэгтэй байгаа хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтыг шилжүүлэхээс өмнө тодорхой хэмжээний төлбөрийг шилжүүлэхийг хүсэх, эсвэл хөрөнгө оруулалтыг баталгаажуулж гэрээний эсвэл хуульчийн төлбөр зэргийг шилжүүлэхийг шаардах гэх мэт.
4. Хуулийн этгээд залилагчид руу төлбөрийг шилжүүлсний дараа санхүүжилтийн төлбөрийг хуулийн этгээд рүү явуулсан хэмээн гадаад гүйлгээний СВИФТ-ийн мессежний баримтын хуулбар, бусад баримт бичгийн хуулбарыг (хуурамч баримт) илгээх.
5. Энэ бүхний эцэст хуулийн этгээдийн данс руу санхүүжилт шилжин орж ирээгүй байх бөгөөд бусад санхүүгийн залилангийн нэгэн адил төлбөрийг хийсний дараа харилцаа холбоо суларч эсвэл тасардаг.

Дараах нөхцөл байдал, шинж тэмдгээр дамжуулан тус залиланг таньж мэдэх боломжтой:

- Албан ёсны цахим хуудасгүй байх;
- Хуулийн этгээдийн гэрчилгээ хуурамч байх;
- Биеэр уулзаж гэрээ байгуулах боломжгүй байх
- СВИФТ баримт нь стандарт баримтаас зөрүүтэй байх;
- Зөвхөн корреспондент банкны харилцаатай банкнаас илгээх мессежинд ашигладаг кодыг баримт дээр бичсэн байх боловч гүйлгээг шилжүүлсэн гэх банк нь корреспондент харилцаатай банк биш байх;
- Илгээсэн баримт бичиг, гэрээ зэрэг нь Апостиль гэрчилгээгээр баталгаажгаагүй байх;
- Хөрөнгө оруулалт, шилжүүлсэн гэх гүйлгээний дүн нь хэт өндөр байх гэх мэт.

СВИФТ-ийн баримтыг хуурамчаар үйлдсэн эсэхийг дараах байдлаар таньж мэдэх боломжтой. Үүнд:

- СВИФТ сүлжээнд өөр улсын өөр банкны харилцагчид төлбөр хийхэд хамгийн түгээмэл ашиглагддаг хэлбэр нь Mt103 юм. Mt103-ыг Mt103/23, Mt103/202 гэх мэтээр өөрчлөх;
- Хүлээн авагчийн хаяг зөрөх;
- Баримтан дээрх үг, үсэг алдаатай байх. Тухайлбал, Swift гэхийг Switf гэх;
- Гүйлгээний хуулган дээр дансны өмнөх болон дараах үлдэгдлийн мэдээллийг оруулсан байх;
- Дээр дурдсан энэ төрлийн залиланг таних бусад шинж тэмдэг ажиглагдах.

## 5. САНХҮҮГИЙН ЗАЛИЛАНГИЙН ЖИШЭЭНҮҮД

### *Жишээ 1. Санхүүгийн залилангаар дамжуулан мөнгө угаасан кейс*

*Богино хугацаанд өндөр өгөөжийг өгнө хэмээн санхүүгийн залилангийн схемд олон нийтийг дотоод болон олон улсын хэмжээнд төөрөгдүүлэн залилсан хэрэг Малайз улсад гарч байв. Малайзын эрх бүхий байгууллагууд тус хэргийг хууль бус, залилангийн шинжтэй хөрөнгө оруулалтын схем зохион байгуулсан хэмээн үйл ажиллагааг нь зогсоов. Тус хэрэгт Малайзын Төв банк, Малайзын Цагдаагийн ерөнхий газар, Дотоод орлогыг удирдах газар, Малайзын компаниудын хороо болон Малайзын хоршооллын нийгэмлэгийн хороо нар мөрдөн шалгах үйл ажиллагаанд хамтран оролцов. Тус бүлэг этгээдүүд нь үндэстэн дамнаж хууль бусаар хадгаламж авсан хэргээр зэргэлдээ орших “А” улсын эрх бүхий байгууллагуудад мөн шалгагдсан байна.*

*Уг хууль бус схемийн үйл ажиллагаанд дараах шинж тэмдгүүд харагдаж байв. Үүнд:*

- Залилан үйлдсэн бүлэглэлийн гаргасан алтаар баталгаажсан гэх криптовалютыг худалдан авч, богино хугацааны гэрээ байгуулж хөрөнгө оруулах, өндөр өгөөж буцааж авахад олон нийтийг уруу татаж төөрөгдүүлсэн;*
- Тухайн криптовалютыг гаргасан этгээдүүд нь арилжааны зорилгоор алт авч хадгалсан хэмээн итгүүлсэн;*
- Сарын 15% хүртэлх өндөр өгөөжийг өгөхөөр амалсан.*

*Мөрдөн шалгах ажиллагааны явцад 4 сая гаруй ам.долларын үлдэгдэлтэй банкны данс болон тансаг зэрэглэлийн автомашин зэрэг бусад хөрөнгийг хураан авчээ.*

*Дараах мөнгө угаах аргуудыг ашигласан байна. Үүнд:*

- Өндөр үнэтэй хөрөнгө худалдан авах;*
- Шилжүүлэг хийх / гадаад банкны данс ашиглах;*
- Виртуал хөрөнгө ашиглах;*
- Хөрөнгө оруулалт гэж авсан мөнгийг бусад бизнесийн мөнгөтэй холих / Co-mingling of funds /*

*Эх сурвалж: Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 2019 оны Типологийн тайлан*

## **Жишээ 2. Зөвшөөрөлгүй/лицензгүй хөрөнгө оруулалтыг олон нийтээс татан төвлөрүүлсэн үйл ажиллагаа - Филиппин Улс**

Албан ёсны байгууллагын зөвшөөрөлгүй, залилан мэхэлсэн шинж чанар бүхий хөрөнгө оруулалтаар дамжин хийгдэх санхүүгийн схемд ойролцоогоор 900 орчим хувь хүмүүс холбогдсон талаар Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэв. Тус сэжигтэй гүйлгээ нь нийт 226 сая филиппин песо (ойролцоогоор 4,274,603 ам.доллар)-ийн дүнтэй байв. Энэхүү схем нь хоёр сарын дотор 100 хувь өгөөжөө өгөх амлалттай, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах явдал байв.

900 хүмүүсийн дийлэнх нь аялал жуулчлалын агентлагийн цалингийн дансаар дамжуулан хөрөнгө оруулалтын мөнгийг хүлээн авсан бөгөөд эдгээр дансууд нь уг схемийг зохион байгуулагч гурван аж ахуйн нэгжийн буюу эцсийн өмчлөгчийн данс маягаар ашиглагдсан хэмээн таамаглажээ. Үнэт цаас, биржийн хороо (SEC) 2019 онд дээрх гурван аж ахуйн нэгжийн эсрэг зөвлөмж гаргаж, эдгээр компаниудад хөрөнгө оруулахаа зогсоохыг олон нийтэд анхааруулсан. Үнэт цаас, биржийн хорооноос цаашид тус залиланд холбогдох этгээдийг татварын байгууллагад мэдэгдэн торгууль болон зохих татварыг ногдуулах болохыг анхааруулсан байна.

Эх сурвалж: Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 2022 оны Типологийн тайлан

## **Жишээ 3. Хөрөнгө оруулалтаар дамжуулан санхүүгийн залилан үйлдэж мөнгө угаав. – Монгол Улс**

Хэсэг бүлэг этгээдүүд (Б.Э, Д.С нар) нь гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдэж бүлэглэн буюу “...” ХХК-ийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч Д.С-ээс 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Эрх олгох тухай” албан бичгээр “...” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Э-д их хэмжээний хэлцэл хийх, компанийг төлөөлөн бүх гэрээ, хэлцэлд төлөөлөх эрхийг олгож, улмаар Б.Э нь 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “...” ХХК-ийн оффисын байранд “...” ХХК-ийн захирал Ш.Б-д “...” ХХК-ийн барилгын хийц материал үйлдвэрлэх “...-1” нэртэй төслийг бие даасан хуулийн этгээд мэтээр тайлбарлаж, “...200 тэрбум төгрөгний үнэлгээтэй, одоогоор 100,000,000 ам.долларын хөрөнгө оруулалт оруулчихсан байгаа, оруулсан хөрөнгөө гуравхан жилийн дотор нөхөж авах боломжтой “...-1” /БҮК-1/ үйлдвэрийн 20 хувийн хувьцааг 2 дахин хямдруулж 20 тэрбум төгрөгөөр өгье, та оруулсан хөрөнгөө буцаан авахыг хүсвэл мөнгө оруулсан өдрөөс эхлэн сарын 1.59 хувийн хүүтэйгээр бодож мөнгөө буцаан авч болно...” гэж итгэл үнэмшил төрүүлсэн байна. Улмаар улсын бүртгэлийн байгууллагад “...” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байгаа, “...-1” /БҮК-1/ үйлдвэрийн бүрдэл хэсэгт хамаарах барилгын объект, 17,360 м.кв талбай бүхий төв цехийн барилга, 8,310 м.кв талбай бүхий бэлэн бүтээгдэхүүний агуулахын барилга, 1,905

м.кв талбай бүхий конторын барилга, 1,490 м.кв талбай бүхий төмрийн агуулахын барилга, 30 м.кв талбай бүхий дулаан дамжуулах барилга болон зам, талбай, дулааны шугам, цэвэр, бохирын шугам, тус үйлдвэрийн тоног төхөөрөмж, бараа материал, “Монгол Улсын ...”-ны зээлээр санхүүжсэн /БҮК-1/ төслийн үр дүнд бий болох эд хөрөнгө, “...” ХХК-ийн дансны авлага, борлуулалтын орлого, банкны харилцах данс, дансны орлого зэрэг хөрөнгийг “Монгол Улсын ...”-наас авсан зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалбар болгож барьцаалсан байгаа атлаа “Хамтран ажиллах гэрээ”-гээр “...-1” /БҮК-1/ үйлдвэрт 20 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд тус үйлдвэрийн 20 хувийг эзэмшүүлнэ” гэж хуурч, гэрээний дагуу хөрөнгө оруулж хувьцааг эзэмших зорилгоор шилжүүлсэн **18,002,140,000** төгрөгийг болон **2,004,235,060** төгрөгийг буюу нийт **20,006,375,060** төгрөгийг 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд өөрсдийн захиран зарцуулах эрхэд буюу Б.Э, Д.С нарын нэр дээрх төгрөгийн болон ам.долларын хамтран эзэмшдэг данснүүдэд шилжүүлэн авч, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж их хэмжээний хохирол учруулан залилсан байна.

Мөн 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд бусдын эд хөрөнгийг хуурч, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж залилсан гэмт үйлдлийн улмаас бий болсон хууль бус эх үүсвэртэй мөнгөн хөрөнгийг буюу өөрсдийн хамтран эзэмшдэг төгрөгийн данс, ам.долларын данснүүдэд иргэн Ш.Б-аас шилжүүлэн авсан 20,006,375,060 төгрөгийн хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах зорилгоор, ... тоот төгрөгийн данснаас 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 3,307,702,980,63 төгрөгийг Э.Ж-ийн дансанд, 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 2,000,000,000 төгрөгийг Э.Ж-ийн дансанд тус тус шилжүүлсэн, Э.Ж-аас 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд төгрөгийн 2 харилцах данс, төгрөгийн хугацаагүй хадгаламжийн 2 данс, ам.долларын хугацаагүй хадгаламжийн 3 дансанд **85 удаа дамжуулан шилжүүлж** “...” ХХК-ийн зээл, цалинд, “...” ХХК-д гэсэн гүйлгээний утгатайгаар болон бэлнээр мөн бэлэн бусаар зарцуулсан, ... тоот ам.долларын данснаас 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 3,958,072,52 ам.долларыг, 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 2,000,000 ам.долларыг буюу нийт 14,696,418,718 төгрөгийг “...” дахь Д.С-гийн ганцаараа эзэмшдэг ... тоот хугацаагүй хадгаламжийн ам.долларын дансанд тус тус шилжүүлснийг Д.С-гээс:

2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл хугацаанд “...” дахь ам.долларын хугацаагүй хадгаламжийн 10 данс, ам.долларын харилцах 1 дансандаа 587 удаа дамжуулан шилжүүлж удирдлагын зардал, “...” ХХК-ийн зээл, цалинд, “...” ХХК-д гэсэн гүйлгээний утгатайгаар болон бэлнээр мөн бэлэн бусаар

зарцуулсан, “...”-д хугацаатай хадгаламжийн хэлбэрээр байршуулсан уг мөнгөн дүнгээс 311,850,104 төгрөгийн хүүгийн орлого олсон зэргээр байнга тогтвортой мөнгө угаасан гэмт хэргийг тус тус үйлдсэн гэмт хэрэгт холбогджээ.

Үүнээс болж дараах арга хэмжээг авсан байна. Үүнд :

- Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокуророос шүүгдэгч Д.С-г Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 1, 3.1 дүгээр зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалт, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан, мөн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад заасан тус тус гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Д.С-г цагаатгасан.

- Шүүгдэгч Б.Э-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад зааснаар “Хуурч, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авч, их хэмжээний хохирол учруулж залилах гэмт хэрэг үйлдсэнд; Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад заасан “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж хууль бус эх үүсвэрийг нуун далдлах зорилгоор өөрчилж мөнгө угаах гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсон.

- Шүүгдэгч Б.Э-ыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад зааснаар 5 (тав) жилийн хугацаагаар хорих ял; Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад зааснаар 2 (хоёр) жилийн хугацаагаар хорих ял тус тус шийтгэсэн.

- Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Э-ад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад зааснаар оногдуулсан 2 жилийн хугацаагаар хорих ялыг мөн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад зааснаар оногдуулсан 5 жилийн хорих ялд нь нэмж, түүний биечлэн эдлэх ялын төрөл, хэмжээг 7 (долоо) жилийн хугацаагаар хорих ялаар тогтоосон.

• Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Э- оногдуулсан 7 жилийн хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр тогтоосон.

• Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Э-аас 20,006,375,060 (хорин тэрбум зургаан сая гурван зуун далан таван мянга жар) төгрөгийг гаргуулж хохирогч “...” ХХК, Ш.Б-д олгохоор тооцсон.

• Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Э-аас гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох 311.850.104 (гурван зуун арван нэгэн сая найман зуун тавин мянга нэг зуун дөрөв) төгрөгийг гаргуулж, улсын төсөвт оруулахаар болсон байна.

Эх сурвалж: Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан

## 6. САНХҮҮГИЙН ЗАЛИЛАНГИЙН ШИНЖ ТЭМДГҮҮД

### 6.1. Санхүүгийн залилангийн үндсэн шинж тэмдэг

- *Маш бага хэмжээний эрсдэлтэй эсвэл огт эрсдэлгүй хөрөнгө оруулалт гэсэн хэдий ч өндөр өгөөж санал болгох:* Эрсдэл, өгөөж хоёр нь хоорондоо шууд хамааралтай үзүүлэлтүүд бөгөөд өгөөж ихсэх тусам эрсдэл дагаад өсдөг. Иймээс өндөр өгөөж санал болгосон хөрөнгө оруулалтаас болгоомжилж дахин нягтлах хэрэгтэй. Ингэхдээ тухайн хөрөнгө оруулалт нь эрсдэл багатай эсвэл эрсдэлгүй үед хэрхэн ийм өндөр өгөөж бий болгосныг шалгахад гадна ижил төрлийн бусад хөрөнгө оруулалт ямар эрсдэлийн түвшинд хэдий хэмжээний өгөөж хүртээж буйг харьцуулан дүгнэх нь зүйтэй юм. Залилан үйлдэгчид хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор ихэвчлэн өндөр өгөөж санал болгогчийг мартаж болохгүй.
- *Шахалт үзүүлэх тактик:* “Хугацаа дуусах дөхөж байна. Амжиж хөрөнгө оруулаарай!”, “Эхний 50 хөрөнгө оруулагчдад зориулсан тусгай санал. Энэхүү боломжийг бүү алдаарай!”, “2,000 гаруй хүн хөрөнгө оруулалт хийгээд байна. Та юу хүлээж байна?”, “Зөвхөн өнөөдөр хөрөнгө оруулбал тусгай хөнгөлөлт эдлэнэ” гэх зэргээр хөрөнгө оруулалтын санал тулгах. Ингэж тулгах нь иргэдийг мөнгөө юу ч бодолгүйгээр, тооцоолол хийх хугацаа олголгүйгээр хөрөнгө оруулахад яаруулж буй хэрэг юм. Шахалтын иймэрхүү арга барил нь хөрөнгө оруулалтаар дамжин хийгдэх санхүүгийн залилан мэхлэх гэмт хэрэгт л голлон ашиглагддаг тул анхаарвал зохистой.
- *Хуурамч бичиг баримт ашиглах:* Залилан мэхлэгчид бусдын итгэлийг олж авахын тулд өөрсдийгөө найдвартай, олон жилийн туршлагатай, удаа дараалан шагнал хүртсэн, хөрөнгө оруулалтаасаа их хэмжээний ашиг хүртдэг хэмээн итгүүлэхээр хуурамч бичиг баримт ашиглан ятгах хандлагатай байдаг. Мөн өнөө үед ихээхэн илэрч буй хандлага нь СВИФТ-ийн баримтыг хуурамчаар үйлдэн залилан хийх тохиолдол ихэсч байна.
- *Албан ёсны зохицуулах байгууллагын зөвшөөрөлгүй байх:* Зарим төрлийн санхүүгийн залилан нь таныг төөрөгдүүлэхийн тулд холбогдох байгууллагуудын зохицуултад байдаг гэж итгүүлэх аргыг ашиглаж магадгүй. Ийм тохиолдолд холбогдох зохицуулагч байгууллагаас нь лавлагаа хүсэх, цахим хуудсанд байршуулсан тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн жагсаалтыг шалгах хэрэгтэй.

Санхүүгийн залиланг илрүүлэх, таслан зогсоохын тулд банк, санхүүгийн байгууллагууд харилцагч, үйлчлүүлэгчдийн гүйлгээний мэдээлэл болох төлбөрийн баримт (төлбөрийн даалгавар), нэхэмжлэх эсвэл гэрээ болон бусад холбогдох баримт бичгийг сайтар шалгаж нягтлан, тухайн гүйлгээтэй холбогдох нөхцөл байдлыг харгалзан үнэлэх шаардлагатай. Иймд банк, санхүүгийн байгууллагын хувьд хамаарах санхүүгийн залилантай холбоотой байж болзошгүй сэжигтэй шинж тэмдгүүдийг дор ангилан жагсаалаа.

Доор жагсаасан шинж тэмдгүүдийн зарим нь хууль ёсны санхүүгийн үйл ажиллагаа байж болох тул банк, санхүүгийн байгууллагууд гүйлгээ, үйлдэл нь санхүүгийн залилантай холбоотой, сэжигтэй байж болзошгүй гэж шууд үзэхээс өмнө эдгээр шинж тэмдгээс гадна

харилцагчийн санхүүгийн гүйлгээ, үйл ажиллагааны түүх гэх мэт тухайн гүйлгээ, нөхцөл байдалтай холбогдох бусад баримт, мэдээллийг харгалзан үнэлэх нь зүйтэй. Хэрэв шаардлагатай гэж үзвэл харилцагчаас асуулт асуух, тайлбар, мэдээлэл авах, нэмэлт баримт бичиг шаардах гэх мэт харилцагч, гүйлгээг нарийвчлан таньж мэдэх арга хэмжээ авах хэрэгтэй.

## 6.2. Санхүүгийн залилангаар дамжуулан мөнгө угааж байж болзошгүй гэж сэжиглэх ерөнхий үндэслэлүүд

- Харилцагч нь олон данс нээн, ижил төрлийн утгаар олон хүмүүсээс мөнгө татах;
- Харилцагчийн дансаар хийгдэж байгаа гүйлгээний дүн, тоо, давтамж нь харилцагчийн ажил эрхлэлт болон хувийн хэрэгтэй нийцэхгүй байх;
- Харилцагчийн дансанд богино хугацаанд олон удаагийн давтамжтай мөнгөн гуйвуулгын үйлчилгээгээр дамжин мөнгө орж ирэх;
- Харилцагч нь олон төрлийн данснаас мөнгө хүлээн аваад, цуглуулж байгаад өөр данс руу шилжүүлэх;
- Хуурамч бичиг баримтыг харилцагч авчрах. Тухайлбал, СВИФТ-ийн баримтын хуурамч хуулбар.

### 6.2.1. Данс нээх үед ажиглагдах шинж тэмдгүүд

- Үйлчлүүлэгч харилцагчаар бүртгүүлэхдээ өөрийн мэдээлэл, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгөтэй холбогдох комплаенсын журмын талаар жирийн бус байдлаар асууж тодруулах эсвэл харилцааны менежер бизнесийн үйл ажиллагааных нь талаар харилцагчаас нарийвчлан асуухад хариулахаас татгалзах, эсвэл тухайн салбарынхаа талаар мэдлэг, мэдээлэл хомс байх;
- Харилцагчийн өгсөн материал төөрөгдүүлсэн шинж чанартай байх эсвэл хуурамч баримт бичиг үзүүлэх ;
- Харилцагч (эсвэл харилцагчтай холбоотой ойрын хүн) эрүүгийн, иргэний гэмт хэрэг болон хууль тогтоомжийн зөрчилд холбогдож байсан байх;
- Ямар нэг тодорхой бизнесийн зорилгогүйгээр харилцагч маш олон данс хөтөлдөг байх.

### 6.2.2. Гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд

- Маш өндөр дүнтэй эсвэл олон удаагийн давтамжтай гүйлгээ хийхийг оролдох;
- Харилцагч зөвхөн бэлэн мөнгөөр гүйлгээ хийдэг байх;
- Бэлэн мөнгө болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний хувьд СМА-нд тайлагнах босго дүнгээс доогуур дүнгээр гүйлгээг тогтмол давтамжтайгаар хийдэг байх;
- Харилцагчийн хувийн хэрэгтэй таарч тохирохооргүй маш өндөр хэмжээний гэнэтийн шилжүүлгийн гүйлгээ дансанд нь орж ирэх, дараа нь тэр даруй мөнгийг бэлнээр гаргаж авах;
- Ямар нэгэн бизнесийн зорилгогүйгээр холбоо хамааралгүй гуравдагч этгээдтэй их хэмжээний шилжүүлгийг байнга хийдэг байх;



- Мөнгө угаах эрсдэл өндөртэй улс орноос тухайн хүний хувийн хэрэг, бизнесийн үйл ажиллагаатай нь холбоо хамааралгүй шилжүүлэг орж ирэх;
- Данс руу орлого орсны дараа тэр дор нь зарлага болгон байнга гаргаж авдаг байх;
- Гүйлгээний гүйцэтгэл, төлбөр тооцоотой холбоотойгоор ижил төрлийн компанитай байнгын тогтмол шилжүүлгийг хийдэг байх;

### 6.2.3. Хуурамч компанитай холбогдон илрэх шинж тэмдгүүд

- Аж ахуйн нэгжийн хувьд компанийн хууль ёсны үйл ажиллагааны талаарх мэдээлэл байхгүй байх;
- Тухайн компаний байршил эсвэл компанийн үйл ажиллагааны төрлийг тодорхойлоход бэрхшээлтэй байх;
- Тухайн компаний ажилтан, удирдлагын албан тушаалтантай холбогдоход бэрхшээлтэй байх;
- Нэг хүн эсвэл нэг ижил хаягийн дор олон компани бүртгүүлэх.

## 7. АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хувьд санхүүгийн залиланг илрүүлэх, таслан зогсооход дараах арга хэмжээнүүдийг үйл ажиллагаандаа баримталвал зохистой. Үүнд:

- Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг чанартай хэрэгжүүлэх;
- Дансны үйл ажиллагааг тогтмол хянах;
- Сэжигтэй гүйлгээг тухай бүрт нь СМА-нд мэдээлэх;
- Залилан, луйвар хийх оролдлогын талаарх мэдээлэх;
- Хохирогчийн данс байршдаг банк, санхүүгийн байгууллага нь залилан байж болзошгүй сэжигтэй гүйлгээ хийгдсэн талаар шилжүүлгийн гүйлгээг хүлээн авагч банк, санхүүгийн байгууллагатай нэн даруй холбоо барьж мэдэгдэх;
- Хэрэв гүйлгээг хуурамч, залилан луйвартай холбоотой гэж үзвэл гүйлгээг шалгаж баталгаажуулах зорилгоор өөрийн дотоод журам, зааврын дагуу шилжүүлэгч банк, санхүүгийн байгууллагатай яаралтай холбогдох, хууль сахиулах байгууллага, СМА зэрэг эрх бүхий байгууллагатай холбогдох;
- Алдсан хөрөнгө, мөнгийг буцааж олж авах магадлалыг нэмэгдүүлэхийн тулд банк, санхүүгийн байгууллага нь хууль сахиулах байгууллагууд болон СМА-нд шаардлагатай бүх мэдээллийг өгч, хамтран ажиллах;
- Банк, санхүүгийн байгууллага нь СМА болон эрх бүхий байгууллагаас гаргасан гүйлгээг түдгэлзүүлэх, царцаах шийдвэрийг хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлж, хамтран ажиллах;
- Мөнгө угаахтай холбоотой үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, цаашид санхүүгийн гэмт хэрэгт ашиглагдах эрсдэлээс сэргийлэх бодлого, журамтай байх;
- Санхүүгийн залилангийн талаар ажилтнуудаа мэдээллээр байнга хангаж ажиллах, ялангуяа шинээр орж ирсэн ажилтнуудад сургалт зохион байгуулж, хэрэв өмнө нь санхүүгийн залилантай холбоотой гүйлгээ хийгдэж байсан бол тус төрлийн гүйлгээ хийгдэхээс сэргийлж ажилтнууддаа танилцуулж мэдээлэл өгөх;
- Данс нээхдээ тухайн харилцагчийн бизнесийн төрөл, бүтцийг үндэслэн харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлж тогтоох, тухайн эрсдэл дээр үндэслэн гүйлгээний хяналтыг янз бүрийн түвшинд хэрэгжүүлэх;
- Харилцагчийг соён гэгээрүүлэх зорилгоор санхүүгийн залилангийн талаар өөрсдийн цахим хуудас, олон нийтийн хэрэгслээр түгээх;
- Гүйлгээг хянах програм хангамжийг сайжруулах.

Мөн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд оролцдог бүх байгууллагын ажилтнууд санхүүгийн залилангийн шинээр үүсч байгаа чиг хандлага, типологи, өөрчлөлт, шинэ мэдээ мэдээллээр өөрсдийгөө хангах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй. Цаашид санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх зорилгоор банк, банкнаас бусад санхүүгийн байгууллага, хууль сахиулах байгууллага болон бусад эрх бүхий байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж туршлага хуваалцдаг байх нь чухал үр нөлөөтэй хэмээн үзэж байна.

## 8. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГААР МЭДЭЭЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛ

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг санхүүгийн залилан зохион байгуулж байгаа эсвэл аливаа хувь хүн, хуулийн этгээд тус залилангийн үйл ажиллагаанд оролцож байж болзошгүй гэж үзвэл Санхүүгийн мэдээллийн албанд 24 цагийн дотор тус сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлагатай. Банк, санхүүгийн байгууллага нь санхүүгийн залилантай холбоотой сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэхдээ аль болох бүх холбогдолтой бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг тайлбар хэсэгт бичиж мэдээлвэл зохино. Иймд дараах мэдээллүүдийг СГТ-аар мэдээлэхийг зөвлөж байна. Үүнд:

- Сэжигтэй гүйлгээний дүн, хийгдсэн огноо, давтамжийн талаар мэдээлэл;
- Шилжүүлэгчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, дансны дугаар, шилжүүлэгч банк, санхүүгийн байгууллагын мэдээлэл;
- Хүлээн авагчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, дансны дугаар, хүлээн авагч банк, санхүүгийн байгууллагын мэдээлэл;
- Корреспондент болон бусад дамжуулагч банкны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- Шилжүүлэгч болон хүлээн авагч нь танай системд санхүүгийн залилантай холбоотойгоор сэжигтэй гүйлгээний тайлан ирүүлж байсан эсэх мэдээлэл;
- Санхүүгийн залиланг хамтран зохион байгуулж байж болзошгүй харилцагчдын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- МҮЭ харилцагчийг яагаад СГТ-аар мэдээлж байгаа, ямар гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй гэж үзэж байгаа талаарх тайлбар;
- Бусад холбогдох мэдээлэл.

## 9. ХАВСРАЛТ

### Хуурамч Свифт мессежний жишээ:

BCBRBRDFORG

BANCO CENTRAL DO BRASIL

SEDE BRASÍLIA-DF

DEPARTAMENTO DA DÍVIDA EXTERNA E DE RELAÇÕES INTERNACIONAIS



TRANSACTION REFERENCE CODE NUMBER: BBARW/522082016/BCB/302710

Ref.: PPP FUNDING/INVESTMENT WITH € 1B CASH FUNDS TO BE CONFIRMED WITH FULL LEGAL RESPONSABILITY VIA SWIFT MT760 FROM BANCO CENTRAL DO BRASIL (ON SWIFT "NET" SYSTEM)

DEAR MISS. JOUMANA [REDACTED],



THIS A SUMMARY OF YOUR ACCOUNT BALANCE AND TRANSACTION

TRANSACTION NUMBER:BCB1B/HSBC/OSIAS/CFLS/JVTRADE/AUG2016

ACCOUNT NAME:CONCEPT [REDACTED]  
ACCOUNT SIGNATORY: JOUMANA [REDACTED] - [REDACTED]  
APPLICANT'S POA & ASSET MANAGER: CARL EDWARD [REDACTED]  
ACCOUNT NO.: [REDACTED]  
AMOUNT:1,000,000,000.00 EURO  
CREDIT DEBIT:CREDIT  
CURRENT BALANCE:1,000,000,000.00 EURO  
PENDING DEBIT:0, 00  
PENDING CREDIT:0,00  
AVAILABLE BALANCE:1,000,000,000.00 EURO

BRASÍLIA, DF-BRAZIL, AUGUST 22, 2016 - 08:19:41

  
OFFICER: ALEXANDRE KIOTO ARAUJO YAMAGUCHI  
TITLE:ANALYST CENTRAL BANK OF BRAZIL  
REGISTRATION: 04494271  
CPF: 695.602.001-78

  
1329676103  
  
OFFICER: MARCIO ANTONIO ESTRELA  
TITLE: HEAD OF SUBUNIT  
REGISTRATION: 67789841

BCBRBRDFORG

BANCO CENTRAL DO BRASIL

SEDE BRASÍLIA-DF

DEPARTAMENTO DA DÍVIDA EXTERNA E DE RELAÇÕES INTERNACIONAIS



TRANSACTION REFERENCE CODE NUMBER: SMDNR/722082016/BCB/302710

Ref.:PPP FUNDING/INVESTMENT WITH € 1B CASH FUNDS TO BE CONFIRMED WITH FULL LEGAL RESPONSABILITY VIA SWIFT MT760 FROM BANCO CENTRAL DO BRASIL (ON SWIFT "NET" SYSTEM)

ACCOUNT NAME:CONCEPT [REDACTED]

ACCOUNT NO.: [REDACTED]

ACCOUNT SIGNATORY:JOU MANA [REDACTED] - [REDACTED]

APPLICANT NAME:CONCEPT [REDACTED]

APPLICANT'S POA &amp; ASSET MANAGER: CARL EDWARD [REDACTED]

BANK OFFICER NAME:MARCIO ANTONIO ESTRELA - HEAD OF SUBUNIT (ID: 67789841)

TELEPHONE NUMBER:+55 61 2626 1535

BANK OFFICER EMAIL:ESTRELA@BCB.GOV.BR

SWIFT CODE: BCBRBRDFORG

SUBJECT:RWA LETTER FOR DELIVERY OF SWIFT MT760 (Blocked Funds)

TRANSACTION NUMBER: BCB1B/HSBC/OSIAS/CFLS/JVTRADE/AUG2016

Dear Sir,

We, BANCO CENTRAL DO BRASIL (CENTRAL BANK OF BRAZIL) located at SETOR BANCÁRIO SUL (SBS) - QUADRA 3, BLOCO B, ED.SEDE, ZIP CODE 70.074-900 BRASÍLIA (DF) BRAZIL represent by the undersign bank officers, hereby confirm with full bank responsibility that we are ready, willing and able to issue and deliver a fully cash backed SWIFT MT760 via Swift.Net (as our Sovereign Bank only utilize Swift.Net), for the fully cash backed investment in the total amount of €1,000,000,000.00/Euro (One Billion Euro currency) in favor of your nominated credit facilitating entity for the benefit of Transaction Code: BCB1B/HSBC/OSIAS/CFLS/JVTRADE/AUG2016. The €1,000,000,000.00/Euro (One Billion Euro currency) is deposited and available as Cash Funds in this banks on Account Number: [REDACTED] for the account holder CONCEPT [REDACTED] as of the date of this transmission.

We confirm with full bank responsibility acknowledge and agree that the above referenced the fully cash backed SWIFT MT760 of the said Cash Funds account will be reserved and blocked for a period of one year and one month from confirming date in favor of the Assets Manager Firm, Bass-Mint Management Group (7574002 Canada inc) duly represented by Mr. Carlo Edward [REDACTED], Sui Juris, holder of a Canadian Passport # [REDACTED], or any person or organization designated by Mr. [REDACTED], to serve as collateral to secure any loan, credit line or credit facilities upon receiving the beneficiary receiving bank account coordinates in order for CONCEPT [REDACTED] (registered office at 19,RUE Jean-Pierre Biermann, Postal Code: L--1268, Luxembourg and Business Registration No. B 194997) to have the "Privilege" to be invited to participate or/and enter in any potential Structured Private Financial Opportunity (Project Funding/PPP).

We also confirm that we have no objection on the content and verbiage of the fully cash backed SWIFT MT760 conforms to URDG 758 Format (with the terms of the ICC latest edition) or/and in accordance with the Verbiage included in "Annex 1".

We further confirm that this the fully cash backed SWIFT MT760 of the said Cash Funds account to be free and clear of all liens and encumbrances and are legally earned. We guarantee delivery of this fully Block Assets as good, cleared, fully transferable, and registered asset:

Thank you for your co-operation. If you have questions, this letter may be confirmed via bank to bank communication using the above reference code and attached authorization to verify documentation signed by the account holder.

The authenticity and validity of this Reading to deliver the fully cash backed SWIFT MT760 of the said Cash Funds account via Swift.Net can be confirmed by

responsible bank inquiry, via Phone, E-Mail and/or SWIFT communication.  
This document may be validated on a Bank to Bank Basis with proper notification.

ANNEX "1"  
MT760 VERBIAGE FORMAT  
FOR CASH FUNDS  
(ICC FORMAT MT760)

FOR THE VALUE RECEIVED, WE, THE UNDERSIGNED, .....BANK, ....., HEREBY ISSUE OUR IRREVOCABLE UNCONDITIONAL TRANSFERABLE, DIVISIBLE, AND WITHOUT PROTEST OR NOTIFICATION, PROMISE TO PAY AGAINST THIS CASH FUNDS WITH ACCOUNT NUMBER.....TO THE ORDER OF .....(BENEFICIARY), THE BEARER OR HOLDER THEREOF, AT MATURITY, THE SUM OF EURO €1,000,000,000.00 (EUR ONE BILLION ONLY) IN THE LAWFUL CURRENCY OF THE EUROS, UPON PRESENTATION AND SURRENDER OF THIS LETTER OF GUARANTEE AT ANY OF THE COUNTERS OF OUR OFFICES AT.....

SUCH PAYMENT SHALL BE MADE WITHOUT SET-OFF AND FREE AND CLEAR OF ANY DEDUCTIONS, CHARGES, FEES, OR WITHHOLDING OF ANY NATURE PRESENTLY OR IN THE FUTURE IMPOSED, LEVIED, COLLECTED, WITHHELD, OR ASSESSED.


THIS SWIFT MT760 INSTRUMENT IS CASH BACKED, DIVISIBLE, ASSIGNABLE, AND TRANSFERABLE WITHOUT PRESENTATION OF IT TO US AND MAY BE RELIED UPON FOR THE PURPOSES OF OBTAINING CREDIT LINES OF LOANS.



THIS SWIFT MT760 INSTRUMENT SHALL BE GOVERNED BY AND SHALL BE CONSTRUED IN ACCORDANCE WITH THE LAWS OF (COUNTRY OF ISSUE). THIS CASH FUNDS DEPOSITED IS AN OPERATIVE INSTRUMENT.

THIS GUARANTEE IS GOVERNED BY THE UNIFORM RULES OF DEMAND GUARANTEES AS SET FORTH BY THE INTERNATIONAL CHAMBER OF COMMERCE LATEST REVISION OF PUBLICATION 600 URDG 758.

YOUR DEMAND FOR PAYMENT SHOULD REACH US NOT BEFORE ..... BUT NOT LATER THAN ..... AFTER WHICH DATE, THIS BANK INSTRUMENT IS EXPIRES IN FULL AND SHOULD BE CONSIDERED NULL AND VOID.

BRASÍLIA, DF-BRAZIL, AUGUST 22, 2016 - 08:19:51

  
OFFICER: ALEXANDRE KIOTO ARAUJO YAMAGUCHI  
TITLE: ANALYST CENTRAL BANK OF BRAZIL  
REGISTRATION: 04494271  
CPF: 695.602.001-78

  
  
8410024138  
OFFICER: MARCIO ANTONIO ESTRELA  
TITLE: HEAD OF SUBUNIT  
REGISTRATION: 67789841

**Шинж тэмдэг 1:** Swift.net нь 1 тэрбум долларын гүйлгээ хийх боломжтой томоохон банкуудын хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн платформ биш юм. Swift.com бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, бүх банкуудын ашигладаг мессеж сүлжээ болно.

**Шинж тэмдэг 2:** СВИФТ-ийн код болон хаягийг сайтар шалгаж байх.

**Шинж тэмдэг 3:** Swift.net-ийг “Switf.net” гэж 2 удаа буруу үсэглэн бичсэн байна.

**Шинж тэмдэг 4:** "as our Sovereign Bank only uses Switf.net" гэж бичсэн буюу тухайн банк нь зөвхөн Switf.net-ийг ашигладаг гэж бичсэн байгаа нь илт залилан луйврын шинж чанартай болохыг илтгэж байна.